



**ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/50

Улиастай

**Итгэмжлэгдсэн төлөөлөгч  
томилох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Г.Доржжанцангийн нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох Захиргааны хэргийн хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн М.Рэнчинбямбыг томилсугай.

2.Захиргааны хэргийн шүүхэд хариуцагчийг бүрэн төлөөлж, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан эрх, үүргийг бүрэн эдлэхийг итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  ӨНӨРБАЯР

